

ДЭЛХИЙН ЧӨЛӨӨТ БҮСҮҮДИЙН ХОЛБОО



WORLD FREE ZONES
ORGANIZATION



Зорилго



Дэлхийн өнцөг булан бүрээс чөлөөт бүсүүдийг нэгтгэж, тэдний эерэг үр нөлөөг гишүүддээ чиглүүлэх, мэдлэг, үйлчилгээгээр хангах замаар зохион байгуулагч орны эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжилд чөлөөт бүсүүдийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх.

Алсын Хараа



Чөлөөт бүсүүдийг хөгжил, эдийн засгийн хөгжил цэцэглэлт, нийгэм-эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хэрэгсэл болгон дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх.

Түүхэн замнал

- * Дэлхийн Чөлөөт Бүсийн Байгууллага (World Free Zones Organization) нь дэлхийн өнцөг булан бүрт чөлөөт бүсүүдийн эрх ашгийг төлөөлөх, хамтын дуу хоолойгоор хангадаг дэлхийн ашгийн төлөө бус байгууллага юм.
- * Дэлхийн Чөлөөт Бүсүүдийн Байгууллага нь АНЭУ-ын дэд ерөнхийлөгч, ерөнхий сайд, мөн Дубайн захирагч Мухаммед Бин Рашид Аль Мактум Шейх-н санаачилгаар 2014 оны 5сард АНЭУ, Дубайд байгуулагдсан.
- * Женев хотод бүртгэлтэй, төв байр нь Дубайн Нисэх Буудлын Чөлөөт Бүсийн 7W барилгад байрладаг.
- * Чөлөөт бүсийн үзэл баримтлал нь сүүлийн жилүүдэд Ази, Ойрхи Дорнод, Африкийн хөгжиж буй эдийн засагтай орнуудад түгээмэл болж байна.
- * Тэднийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, зохих дэмжлэгийг авахын тулд эдгээр бүсүүдийн орчин үеийн дэд бүтцийн үлгэр жишээ, ажлын байрыг бий болгох, үйлчилгээ, ложистик, тээврийн сүлжээг нэгтгэгч(үйлчилгээ үзүүлэгч) байх үүргийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.
- * Бүсүүд нь олон орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд аль болох их нөлөө үзүүлэхийн тулд тэднийг нэгтгэх дэлхий нийтийн холбоо хэрэгтэй. Тэдний ашиг сонирхлыг төлөөлж, ололт амжилтаа хуваалцаж, тасралтгүй эерэг хөгжлийг нь дэмжиж чаддаг байгууллага. Энэ хэрэгцээг хангахын тулд Дэлхийн FZO байгуулагдсан.

Зорилтууд

Дэлхийн FZO-ийн Удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлага нь холбооны бүрэн эрхийг бүрдүүлж, Дэлхийн FZO-ийн бүх үйл ажиллагааны үндэс суурь болох хэд хэдэн үндсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

1. Чөлөөт бүсүүд; бүс нутгийн, үндэсний, дэд, орон нутгийн чөлөөт бүсийн холбоод; чөлөөт бүсийн зөвлөх, зөвлөхүүд; чөлөөт бүсийн хэрэглэгчид; сонирхсон төрийн байгууллагууд, олон улсын худалдаатай холбоотой байгууллагуудыг мэдлэг солилцох, боловсрол, сургалт, networking, бизнесийг хөгжүүлэх чиглэлээр нэгтгэх
2. Гүнзгийрүүлсэн судалгаа, ойлголтыг олж авах боломжоор дамжуулан дэлхий даяарх чөлөөт бүсүүдэд суралцаж, хөгжиж, цэцэглэн хөгжих форумыг зохион байгуулах.
3. Дэлхийн болон орон нутгийн зах зээлд эдийн засгийн экосистемийг сайжруулах чөлөөт бүсийн “хамгийн шилдэг” стандарт, чөлөөт бүс байгуулах, удирдах удирдамжийг бий болгох.
4. Чөлөөт бүсийн талаарх мэдлэгийг олон улсын хэмжээнд цуглуулах, бий болгох, өргөжүүлэх, түгээх
5. Чөлөөт бүсийн талаарх ойлголтыг дэлхийн хэмжээнд сайжруулж, орон нутгийн эдийн засагт үнэтэй хувь нэмэр оруулж, тогтвортой бизнесийг дэмжих бүс болгон харуулах(ойлгуулах).
6. Гишүүд, Түншүүд, Ажиглагчдад тусгайлсан үйл ажиллагаа, захиргааны, боловсролын болон networking үйлчилгээг сургалт, түүнчлэн биет болон цахим мэдээллээр хангах
7. Шинэ чөлөөт бүсүүдийг олон улсын хэмжээнд хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгөх

Гишүүнчлэлийн давуу талууд

- * Мэдлэг, Сүлжээ, Дэмжлэг гэсэн гурван үндсэн үйлчилгээний цэс дээрээс салбарын судалгаа, үйл ажиллагааны туслалцаа, өндөр түвшний сургалт, networking үйлчилгээ, арга хэмжээнүүдээс ашиглаж болох давуу талтай.
- * Төлбөртэй гишүүд дэлхийн чөлөөт бүсүүдийн талаарх хамгийн сүүлийн үеийн судалгааг хялбархан авах боломжтой онлайн портал, мөн сар бүр гаргадаг мэдээллийн товхимол, салбарын гол боломжууд болон бэрхшээлүүдийг шийдвэрлэх тогтмол мэдээллийн товхимолд хандах боломжтой болно.
- * World FZO-ийн арга хэмжээ нь гишүүдэд өндөр түвшний бизнесийг хөгжүүлэх, зөвлөхүүд, үйлчилгээ үзүүлэгчид, бодлого боловсруулагчид, олон талт байгууллагууд болон дэлхийн өнцөг булан бүрээс бизнесийн гол шийдвэр гаргагчидтай стратегийн networking байгуулах боломжийг олгодог.
- * Гишүүд, чөлөөт бүсүүд болон тэдгээрт бүртгэлтэй компаниудад зориулсан олон тооны дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, боловсролын хэрэгслээс ашиг хүртэх бөгөөд жилийн турш олон төрлийн семинар, онлайн вебинараар дамжуулан хүргэх болно.